

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 17 дугаар зүйлийг үндэслэн Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын, Ховд аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Үенч сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Цэцэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Зэрэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Санхүүгийн албаны даргын, Ховд аймгийн Цэцэг сумын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлаж байна.

### Нэг. Сонгон шалгаруулалтын зорилго

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын, Ховд аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Үенч сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Ховд аймгийн Цэцэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Зэрэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Санхүүгийн албаны даргын, Ховд аймгийн Цэцэг сумын Санхүүгийн албаны даргын албан тушаалын сул орон тоог сонирхогч иргэдээс тус тус өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд оршино.

- Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”,
- Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ыг Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) гэсэн цахим хуудсанд тавьсан бөгөөд бүртгүүлэх иргэд энэхүү журам, заавартай заавал танилцсан байна.

### Хоёр. Сонгон шалгаруулалтын бүртгэл

- Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд **тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.

Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар тухайн зарлагдсан сул ажлын байранд тавигдсан 4 ерөнхий шаардлага (БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ, МЭРГЭШИЛ, ТУРШЛАГА)-ыг бүгдийг нь хангасан иргэн л бүртгүүлэх боломжтой бөгөөд энэ нь тухайн

иргэн “Баримт бичгийн шалгалт”-д “Тэнцсэн” гэсэн үнэлгээ авч байна гэсэн үг юм.  
Тухайлбал:

- **”Боловсролын шаардлага”**: Бакалаврын боловсролын зэргийн шаардлага тавигдсан ажлын байранд бакалаврын дээд боловсролын зэрэгтэй иргэн бүртгүүлэх боломжтой.
- **”Мэргэжлийн шаардлага”**: Их, дээд сургуульд суралцан эзэмшсэн үндсэн мэргэжлийг ойлгоно. Үүнд: Их эмч, нягтлан бодогч гэх мэт. /Их, дээд сургууль төгссөн **диплом дээрх эзэмшсэн мэргэжлийн нэр** нотолгоо болно/
- **”Мэргэшлийн шаардлага”**: Их, дээд сургуульд суралцан төгсөж, бакалаврын дээд боловсрол, тодорхой мэргэжил эзэмшсэний дараа үндсэн мэргэжлээрээ болон өөр чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, үүний дотор тодорхой хугацаанд тухайн зарлагдсан чиглэлээр курст суралцсанаас эхлээд магистр, докторын зэрэг хамгаалсан гэх мэт сургалт, дадлагажилтад ямар нэг хэлбэрээр хамрагдсан байхыг ойлгоно. /Энэ тухай холбогдох диплом, гэрчилгээ/сертификат нотолгоо болно/
- **”Туршлагын шаардлага”**: “Мэргэжлээрээ ажилласан байх” гэснийг тухайн мэргэжлээрээ улсын болон хувийн хэвшилд ажилласныг ойлгоно. Ажилласан жилийг Иргэний хуулийн 71 дүгээр зүйлд заасан хугацаа тооцох журмын дагуу хоногоор тооцдог. Жишээ нь, мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх шаардлага тавигдсан байна гэвэл яг хоногоороо тооцоход 365 хоног гүйцсэн байх ёстой гэсэн үг. /Энэ хугацааг тооцохдоо **Нийгмийн даатгалын дэвтрийн “Ажилд орсон, шилжсэн, чөлөөлсөн”** гэсэн хүснэгтэд бичигдсэн ажилласан хугацааг баримтална/.

Хэрэв тухайн зарлагдсан сул ажлын байранд тавигдсан 4 ерөнхий шаардлага (боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага)-ыг бүрэн хангаагүй иргэнийг бүртгэвэл, энэ нь Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн, ёс зүйгүй үйлдэл болох тул бүртгэл явуулж байгаа ажлын хэсэг ийм иргэнийг бүртгэх боломжгүй гэдгийг урьдчилан анхааруулж байна.

- Сонгон шалгаруулалтанд өрсөлдөх иргэдийн материалыг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 209 тоот өрөөнд **2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09.00-12.30, 13.30-17.00** цагийн хооронд хүлээн авна.

**Гурав. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэн дор дурдсан материалыг бүрдүүлэн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:**

- Төрийн албан хаагчийн анкет (маягт № 1);
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт; /Гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын газраар Монгол хэл дээр хөрвүүлсэн байх/
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан бол гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
- Монгол Улсын иргэний үнэмлэхний эх хувийг хуулбарын хамт;
- Ажилласан жилийг тооцох Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн эхний нүүр хуудсыг хөдөлмөрийн үйл ажиллагааны хөдөлгөөнийг баталгаажуулсан бусад хуудасны хуулбар, эх хувийн хамт /ажилласан жилийг тооцох тул хөдөлмөрийн үйл ажиллагаагаа хөдөлмөрийн болон

нийгмийн даатгалын дэвтэрт бичигдсэн он, сар, өдрөөр нь нарийвчлан бичиж бэлтгэж ирэх/,

- Ажил байдлын тодорхойлолт;
- 4x3-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг/1 ш нь анкет дээр наагдсан байх/;
- Цэргийн үүрэгтний үнэмлэхний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн байх/ /Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4-д заасны дагуу 1990 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс хойш төрсөн хүмүүст хамаарна /

Дээрх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтын хуваарь, хугацаа**

- Сонгон шалгаруулалтын комисс болон ажлын хэсэг зарлагдсан ажлын байранд бүртгүүлэхээр хүссэн иргэдийн материалыг тухайн ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан эсэхэд нэг бүрчлэн тулган шалгаж, уг ажлын байранд тавигдсан шаардлага хангаагүй иргэний материалыг буцаана.

- **2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 09.00 цагт** сонгон шалгаруулалт эхлэх бөгөөд доорхи байдлаар зохион байгуулна.

1. **Удирдах ур чадварын түвшингийн шалгалт** /Хууль эрх зүйн чиглэлийн сорилын 60 хувьд зөв хариулж, босго оноог хангасан иргэн дараагийн шалгалт /Мэдээллийн технологийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт болон Бичгийн шалгалт/-ад орно/

2. **Ярилцлагын шалгалт** /Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох/

- Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд орох иргэн **Иргэний үнэмлэхтэйгээ** ирнэ.

### **Тав. Ажлын байранд тавигдсан шаардлага**

Сонгон шалгаруулалтад орох иргэн нь Төрийн албаны тухай хуулийн 10.1-д заасан ерөнхий шаардлага болон томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан ажлын байранд тавигдах дараах шаардлагыг хангасан байна:

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын** ажлын байрны шаардлага:

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Эрх зүйч
	Мэргэшил	Эрүү, иргэн, захиргааны эрх зүйгээр мэргэшсэн байх
	Туршлага	Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан байх



	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Баримт бичиг боловсруулах чадвартай</li> <li>- Албан хэрэг хөтлөх чадвартай</li> <li>- Монгол хэл бичгийн найруулгын чадвар эзэмшсэн байх</li> <li>- Компьютер, гадаад хэлний мэдлэгтэй байх</li> </ul>
	Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахих, хээл хахууль, авлигаас хол байх</li> <li>- Нууц хадгалах</li> <li>- Хууль, эрх зүйн зохих мэдлэгтэй</li> <li>- Ачаалал дааж багаар болон бие даан ажиллах</li> </ul>

**Ховд аймгийн Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	<b>Ажлын байранд тавигдах шаардлага</b>
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Эрх зүй, эдийн засагч, санхүүч, төрийн удирдлага, бусад
	Мэргэшил	Төрийн удирдлага, хүний нөөцийн удирдлагаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх
	Туршлага	Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан, удирдах ажил 3-аас доошгүй жил хийсэн байх
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, манлайлах</li> <li>- Асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх</li> <li>- Бодлогын баримт бичиг боловсруулах</li> <li>- Компьютерийн хэрэглээний программ бүрэн эзэмшсэн</li> <li>- Харилцааны өндөр соёлтой байх</li> </ul>
	Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль тогтоомж, ТЗАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, албаны нууцыг хадгалах</li> <li>- Нийгэм, сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшсөн</li> <li>- Судалгааны арга зүй, боловсруулалт, дүн шинжилгээ хийх чадвартай байна</li> </ul>

**Ховд аймгийн Үенч сумын Засаг даргын Тамгын газрын даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	<b>Ажлын байранд тавигдах шаардлага</b>
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Багш, эрх зүйч, эдийн засагч бусад
	Мэргэшил	Төрийн захиргаа болон нийгмийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх
	Туршлага	Төрийн байгууллагад 10, удирдах албан тушаалд 5-аас дээш жил ажилласан байх, төрийн захиргааны байгууллагад ажилласан байх
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Баримт бичиг боловсруулах чадвартай байх</li> <li>- Эрх мэдлийн хүрээнд бусдад нөлөөлөх, урам хайрлах</li> <li>- Компьютерийн өргөн хэрэглээний программыг зохих хэмжээнд эзэмшсэн байх</li> <li>- Төсөв санхүүгийн талаар мэдлэгтэй байх</li> <li>- Баг бүрдүүлэх, аливаа ажлын уялдаа холбоог зохицуулах</li> <li>- Харилцааны өндөр соёлтой байх</li> <li>- Манлайлах, төлөвлөх, зохион байгуулах, хянан зохицуулах чадвартай байх</li> </ul>
	Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих</li> <li>- Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалах</li> </ul>

		- Байгууллагын соёлд суралцсан байх - Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар болон тогтвор суурьшилтай ажиллах
--	--	---

**Ховд аймгийн Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Төрийн удирдлага, хүний нөөцийн удирдлагаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх
	Мэргэшил	Төрийн захиргаа болон нийгмийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх
	Туршлага	Төрийн үйлчилгээ болон захиргааны байгууллагад удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх
	Ур чадвар	- Удирдлагын арга барил эзэмшсэн - Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, манлайлах - Үр дүнд чиглэн ажиллах - Бодлогын баримт бичиг боловсруулах - Компьютерийн өргөн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн - Багаар ажиллах чадвартай - Хууль эрх зүй, эдийн засгийн мэдлэгтэй - Хэлний мэдлэгтэй
	Тусгай шаардлага	- Хууль дээдлэх, төрийн албаны болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйг сахих - Нууц хадгалах эрхтэй байх - Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх

**Ховд аймгийн Цэцэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Төрийн удирдлагын менежер
	Мэргэшил	Хамт олноо манлайлах чадвартай
	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш ажилласан туршлагатай
	Ур чадвар	- Багаар ажиллах болон харилцааны ур чадвартай байх - Өөрийгөө хөгжүүлж, мэдлэгээ бусадтай хуваалцаж, оновчтой шийдвэр гаргаж чаддаг байх - Байгууллагын нийтлэг зорилгод хүрэхийн төлөө ажиллаж чаддаг байх -Ажилдаа сэтгэлээсээ ханддаг байх -Бусдыг анхааралтай сонсож чаддаг байх - Ажилтныхаа үзэл бодлыг хүлээн зөвшөөрч чаддаг байх
	Тусгай шаардлага	-Төрийн албаны ёс зүйг чанд сахиж, нууц хадгалах, ашиг сонирхолын зөрчилгүй байх - Илүү цагаар ажиллах чадвартай байх

**Ховд аймгийн Зэрэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Нийгмийн ажилтан, Төрийн удирдлагын менежер
	Мэргэшил	НӨУБ-ын чиглэлээр мэргэшсэн - Энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ, дипломын ажил хийсэн, дипломын дараах мэргэшсэн сургалтад хамрагдсан байх

	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш ажилласан туршлагатай
	Ур чадвар	Багаар ажиллах, баг бүрдүүлэх ур чадвартай байх - Компьютерийн өргөн хэрэглээний программ дээр ажиллах, сүлжээнээс мэдээлэл авах, илгээх чадвартай - Эрхэлсэн ажлынхаа хүрээнд бусдад нөлөөлөх, баримт бичиг боловсруулах чадвартай байх
	Тусгай шаардлага	- Хууль, эрх зүйн зохих мэдлэгтэй, хяналт, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх - Тухайн орон нутагт 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллах бүрэн бололцоотой байх - Хууль журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах - Байгууллага, хувь хүний нууцыг чанд сахиж ажиллах - Бүтээлч идэвх санаачлагатай байх - Харилцааны өндөр соёлтой байх - Гадаад хэлээр мэдээлэл хүлээн авах чадвартай байх

**Ховд аймгийн Мөст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Төрийн захиргаа, удирдлагын менежер
	Мэргэшил	
	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан байх
	Ур чадвар	Өөрчлөлтийг байнга мэдэрч, манлайлах чадвартай, зарчимч, шударга байх, илтгэх, бичих, мэдээлэл боловсруулах ур чадвартай, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадвартай
	Тусгай шаардлага	Хууль журам, ёс зүйг чанд сахидаг, нууц хадгалах чадвартай, харилцааны өндөр соёлтой, сахилга бат өндөртэй, идэвх санаачлагатай, илүү цагаар ажиллах, зохион байгуулах ур чадвар сайтай, хяналт, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай байх

**Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Төрийн захиргаа, удирдлагын менежер
	Мэргэшил	
	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан байх
	Ур чадвар	Өөрчлөлтийг байнга мэдэрч, манлайлах чадвартай, зарчимч, шударга байх, илтгэх, бичих, мэдээлэл боловсруулах ур чадвартай, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах чадвартай
	Тусгай шаардлага	Хууль журам, ёс зүйг чанд сахидаг, нууц хадгалах чадвартай, харилцааны өндөр соёлтой, сахилга бат өндөртэй, идэвх санаачлагатай, илүү цагаар ажиллах, зохион байгуулах ур чадвар сайтай, хяналт, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай байх

**Ховд аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Эрх зүйч, төрийн удирдлагын менежер, багш, барилгын архитектур, дизайн инженер
	Мэргэшил	
	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш ажилласан туршлагатай
	Ур чадвар	Хууль хэрэглэх чадвартай байх, компьютерийн өргөн хэрэглээний

		программуудыг ашиглаж чаддаг байх
	Тусгай шаардлага	Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахих, нууц хадгалах

**Ховд аймгийн Мөнххайрхан сумын Санхүүгийн албаны даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Эдийн засаг, санхүү, хуульч, эрх зүйч, бусад
	Мэргэшил	Төрийн еолон нутгийн удирдлагаар мэргэшсэн
	Туршлага	Төрийн албанд 3-аас дээш жил ажилласан байх
	Ур чадвар	Манлайлах, харилцааны ур чадвартай - Баримт бичиг боловсруулах - хэрэглээний программууд дээр ажилладаг байх
	Тусгай шаардлага	- Хууль тогтоомж, ТЗАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, - Банкинд өр зээлгүй, ялгүй, харилцааны өндөр соёлтой, сахилга бат өндөртэй, идэвх санаачлагатай, илүү цагаар ажиллах, зохион байгуулах ур чадвар сайтай, хяналт, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай байх

**Ховд аймгийн Цэцэг сумын Санхүүгийн албаны даргын ажлын байрны шаардлага:**

Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Ажлын байранд тавигдах шаардлага
	Боловсрол	Дээд боловсролын бакалавраас дээш зэрэгтэй байх
	Мэргэжил	Нягтлан бодогч
	Мэргэшил	
	Туршлага	Мэргэжлээрээ ажилласан байх
	Ур чадвар	- Баг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах
	Тусгай шаардлага	- Урлаг, спортын авьяастай байх - Ес зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх - Нууцыг чанд хадгалах - Харилцагчдад чирэгдэлгүй үйлчлэх

- Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын **70432506, 88039925** утсаар холбогдож лавлагаа авч болно.

**Зургаа. Сонгон шалгаруулалтанд орох иргэдийн уншиж судлах эрх зүйн баримт бичиг**

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн алба, төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж болон Төрийн албаны зөвлөлөөс бэлтгэн гаргасан “Төрийн албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад бэлтгэх гарын авлага”-тай танилцаж, бэлдэнэ үү.

**ХАРИЛЦАХ ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар**  
209 ТООТ ӨРӨӨ, УТАС: 70432506, 88039925